



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 5 нэрийн, нийт 50,581,313.00 (тавин сая таван зуун наян нэгэн мянга гурван зуун арван гурав) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга хошууч генерал Г.Ариунбуян, Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газрын дарга Б.Анхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3. Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132001388

13-r huraldaan.docx



Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 26 дугаар сарын 10-ны өдрийн
286 дугаар тогтоолын хавсралт

СҮХБААТАР ДҮҮРГИЙН АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ҮНДСЭН

ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ

АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	ЗИЛ-130 АЦ-40 галын автомашин	1986/1986	1	7,000,000.00	7,000,000.00	7,000,000.00	-
2	Ландкрузер-80 улсын дугаар 99-89 СҮА	1992/2008	1	23,000,000.00	23,000,000.00	23,000,000.00	-
3	УАЗ-31512-0 улсын дугаар 57-60 СҮЭ	2006/2006	1	14,060,000.00	14,060,000.00	14,060,000.00	-
4	ГАЗ-66 улсын дугаар 95-00 СҮА	1986/2006	1	2,721,313.00	2,721,313.00	2,721,313.00	-
5	Мотоцикль /Dayun/	2013/2014	2	1,900,000.00	3,800,000.00	3,800,000.00	-
			6		50,581,313.00	50,581,313.00	-
					(тавин сая таван зуун наян нэгэн мянга гурван зуун арван гурав)	(тавин сая таван зуун наян нэгэн мянга гурван зуун арван гурав)	